

## **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 5 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

### **НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

#### **АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг 3 удаа хийж, Хүмүүнлэгийн хөтөлбөрийн хэрэгжилт, Ус хангамж, ариутгах татуургын хамгаалалтын бүс тогтоох тухай 2015 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, Ариутгах татуургын шугам сүлжээний хамгаалалтын бүс тогтоох тухай 2018 оны 37 дугаар тогтоолын хэрэгжилт, “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөрийн хэрэгжилт, “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” хөтөлбөрийн хэрэгжилт, Гэр бүл хүний хөгжлийн төвийн үйл ажиллагааны тайланд тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт (2018 оны 27\03-04), Хархорин сумын Спортын ордныг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Зэвэгийн Ойдовын нэрэмжит болгох тухай, Хөрөнгө шийдвэрлэх тухай, Төрийн дээд шагналд уламжлах тухай Үндэсний аюулгүй байдлыг мэдээллээр хангах ажлын хэсгийн үйл ажиллагааны тайлангийн тухай, 2018 оны 34/10-01 тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт, Үндэсний аюулгүй байдлыг мэдээллээр хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай, Аймгийн худалдаа үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журмын хэрэгжилт, 2019 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн сургалтын зардлыг батлах тухай, Орон нутгийн өмчийн тайлан, төсөвт өөрчлөлт оруулах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж, 12 тогтоол гаргаж, нэг асуудалд тэмдэглэлээр үүрэг өгөв.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бүх сумдад “Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн, нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулах ажлын хэсэг Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин, Бат-Өлзий суманд төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлэв.

“Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн 13.2.1, 13.2.2 дахь заалтын дагуу нөхөх олговор авахаар хүсэлтээ гаргасан Арвайхээр сумын харъяат Сэнгидоржийн Банзаржавын нөхөх олговрын нэхэмжлэл нь шүүхийн шатанд шилжиж, Есөнзүйл сумын иргэн Дуламсүрэнгийн Цэдэвийн нэхэмжлэл сонинд зарлагдсан байна. Улс төрийн хэлмэгдэгч Давдинжавын Гэндэндоржийн нөхөх олговрын нэг сая төгрөгийг түүний ач дүү болох Арвайхээр сумын иргэн Дуламдоржийн Бүрэнбаярт гардууллаа.

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академиас зохион байгуулсан “ИТХ-ын Төлөөлөгч, Ажлын Албаны чадавхийг бэхжүүлэх нь” багцын сургалтанд аймгийн ИТХ-ын Ажлын Албаны ажилтнууд хамрагдаж, мөн Нийслэлийн ИТХ-ын үйл ажиллагаатай танилцлаа.

#### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу Арвайхээр суманд орчин үеийн дуу, дүрсний өндөр технологи бүхий 180 хүний суудалтай “Орхон Синима” кино театрыг ашиглалтанд оруулав. Уг кино театрыг ашиглалтад оруулснаар Улаанбаатар хотод нээлтээ хийсэн шинэ уран бүтээлийг тухай бүрт үзэх боломжтой болж, хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин шинээр нэмэгдлээ.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам”-ын төсөл хэлэлцэх, Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах тухай тогтоолын төсөл, Түрээсийн орон сууцны талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төсөл, Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хяналт тавих журамд өөрчлөлт оруулах тухай, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07/05 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн худалдаа үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, олгох хяналт тавих журам”-ын хэрэгжилтийн явц, үр дүн, Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн дахин үнэлгээний дүнг танилцуулах, Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэгийн тайлан, дүнг танилцуулах, Сум дундын ойн ангийн дүрэм, бүтэц орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” зохион байгуулах шийдвэрийн дагуу аймгийн хэмжээнд бэлтгэх ажлын төлөвлөгөө, салбар комиссын бүрэлдэхүүнийг томилон, аргачлалын дагуу сургалт зохион байгууллаа. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт аймгийн хэмжээнд нийт 215 төсөвт байгууллагууд хамрагдана.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 89 дүгээр тогтоолын дагуу Өндөр гэгээний өлгий нутаг Есөнзүйл сумын нутагт орших Зүүн хайрханы тэнгэрийг тайх тахилгын ёслолыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газар хамтран 2 дахь удаагаа тайж тахилаа. Энэхүү үйл ажиллагаанд УИХ-ын гишүүд, аймаг, сумдын удирдлагууд, нутгийн уугуул, суугуул иргэд болон зэргэлдээх сумдын иргэд, хөдөлмөрчид өргөнөөр цугларан, чуулж, сүслэн, залбирав.

Арвайхээр суманд шинээр баригдах усан спортын цогцолборын барилгын ажлыг эхлүүлэв. Улсын төсвийн 3.0 тэрбум, орон нутгийн төсвийн 1.0 тэрбум нийт 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий бөгөөд тус төв ашиглалтад орсноор 5 замтай усан бассейн, боулинг, фитнес зэрэг хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх, усан спортыг хөгжүүлэх орчин нөхцөл бүрдэнэ.

“Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд Арвайхээр сумын Дэлгэрэх голын дагуу цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нарс, улиас, монос зэрэг 3000 гаруй мод суулган, хамгаалах хайс барьж, усалтын асуудлыг шийдвэрлэх, арчилгаа усалгааг тогтмол хийх 3 хүний орон тоог бий болгоод байна. Мөн Солонгос улсын Ханнара Төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр уг цэцэрлэгт хүрээлэнг тохижуулж хүндэтгэлийн хөшөө, ногоон байгууламжийг бий болгов.

БНХАУ-ын Элчин сайдын яамтай хамтран “Хятадын аялал жуулчлал, соёлын өдөрлөг”-ийг Арвайхээр, Хужирт, Хархорин сумдад зохион байгуулагдаж, Монгол, Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд аймгийн удирдлагуудтай санамж бичиг байгуулж, гэрэл зургийн үзэсгэлэн, Хүүхдийн номын санд ном хандивлах арга хэмжээ, урлагийн тоглолт, Хужирт суманд бизнес эрхлэгчдийн форум зэрэг ажлууд зохион байгуулагдлаа.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ**

Улс, орон нутгийн төсвийн 43 байгууллагын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг ханган төлбөр тооцоог гүйцэтгэж 5-р сард 7915 ширхэг төлбөрийн хүсэлтээр 35.749.236.916,15 төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

### **ТАТВАРЫН ХЭЛТЭС**

Эхний 5 сарын байдлаар 5 хуулийн этгээд нэмж бүртгүүлж, 1303 хуулийн этгээд, 129 салбар газар 604 төрийн бус болон төсөвт байгууллага, 28189 иргэний бүртгэлтэй нийт 30221 бүртгэлтэй татвар төлөгчийн бааз суурьтай үйл ажиллагаа явуулж байна.

Улсын төсөвт 1984.8 сая төгрөг, аймгийн төсөвт 2747.6 сая төгрөг, сумын төсөвт 1545.6 сая төгрөг, нийт 6277.9 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

Татварын удирлагын нэгдсэн систем хэрэгжиж нэхэмжлэхэд суурилсан төлбөрийн даалгаварын дагуу 78 нэхэмжлэхийн код олгоод байна. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 7 хоногоор ээлжлэн байцаагч нар үйлчилгээ үзүүлэн 201 иргэд үйлчилгээ үзүүлэн ажилсан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын 1000,0 мянган төгрөг хожсон 1 иргэний материал хүлээн авч ТЕГ-т хүргүүлэв. Жижиг дунд үйлдвэр эрхлэгч 1 иргэнд гэрчилгээ олгон ажиллсан.

Татварын Ерөнхий Газрын даргын 2019 оны Н/40 дүгээр тушаалаар баталсан "Татварын хяналт шалгалтанд хамруулах татварын хяналт шалгалт хийх графикийг гарган хэлтсийн даргаар батлуулж төлөвлөгөөтөөр 10, төлөвлөгөөт бусаар 2 ААН-ийг шалгав. Нийт 1304023,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 125036,5 мянган төгрөгийн нөхөн татвар торгууль алдангийн акт шийдвэр гаргалаа.

Татварын ерөнхий газраас ирүүлсэн 2018 онд Нийгмийн даатгалын тайлан тушаасан аж ахуйн нэгж байгууллагын судалгааны дагуу 68 иргэн, ААНБ-тай холбогдож цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын нөхөн тайланг авч 3044,4 мянган төгрөг ногдуулсан. Бусад байгууллагын хүсэлтээр 1 ААНБ-ын эрсдлийг тооцож хяналт шалгалтын тасагт шилжүүлсэн. Монгол банкинд алт тушаасан иргэдийн судалгаанд шинжилгээ хийж 8 иргэний 3 иргэнд ногдуулалт хийж 1480,0 мянган төгрөгийг ногдуулан ажилсан. 1 иргэнийг харьяалалын дагуу шилжүүлсэн.

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС**

Даатгалын сангуудын төлөвлөгөө 1706,5 сая төгрөг, гүйцэтгэл 1672,3 сая төгрөгийг төвлөрүүлж, сангийн төлөвлөгөө 98 хувар биелжээ.

Энэ сард шинээр 17 ажил олгогчийн 111 даатгуулагч шинээр албан журмын даатгалд хамрагдсан, 905 ажил олгогчийн 11895 даатгуулагч албан журмын даатгалд, 7356 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдлаа.

Аймгийн хэмжээнд нийт 1536 даатгуулагчдад тэтгэмжийн сангаас 1057,4 сая төгрөгийн тэтгэмж олгожээ. Мөн 88 иргэний өргөдлийг хүлээн авч хууль эрх зүйн дагуу шийдвэрлэсэн 84, хугацаа болоогүй 3 иргэний өргөдөл байна.

ЭХМК-ын 4 удаагийн хурлаар нийт 190 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцсэн ба үүнээс шинээр 29, цуцалсан 10, сунгасан 151 хүний хөдөлгөөнийг мэдээллийн баазад оруулсан.

Есөнзүйл сумын дахин магадлагааны хурлыг зохион байгуулж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон 99 хүнээс нийгмийн даатгалын сангаас 26 иргэн тэтгэвэр авч, 94 даатгуулгуулагчийг хурлаар орж хэлэлцүүлэн, 86 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг хэвээр сунгаж, 1 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг бууруулж, 1 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг

нэмэгдүүлж, 4 хүний хугацааг өөрчлөн, 1 хүнийг цуцалж, 1 хүнийг оношлогоо шинжилгээнд дахин магадлахаар, дахин магадлагаанд ороогүй 5 хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг төвийн ЭХМК-оор оруулахаар шийдвэрлэлээ.

### **Санхүүгийн хяналт, аудитын алба**

Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2019 оны 4 дүгээр ьсарын 15-ны өдрийн 29/09 тоот удирдамжийн дагуу БОЭТөвийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийтдээ 7142,6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 5 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлээ.

Мөн Арвайхээр, Өлзийт, Хужирт сумдын сум хөгжүүлэх сангийн 2017,2018 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж явцын болон хугацаа хэтрэлтэй зээл , зээлийн хүүг төлүүлэхээр Хужирт суманд 11381,0 мян/төг-ийн албан шаардлага, Өлзийт суманд 8515,8 мян/төг-ийн улсын ахлах байцаагчийн акт, 20490,9 мян/төгрөгийн албан шаардлага, Арвайхээр суманд 381555,1 мян/төгрөгийн албан шаардлага хүргүүлээ

Мэргэжлийн хяналтын газартай хамтран Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, аймгийн засаг даргын тамгын газар, мэргэжлийн хяналтын газар, прокурор, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Арвайхээр сумын 1-р цэцэрлэг болон иргэдэд ээлжийн амралт, хууль тогтоомж, төрийн жинхэнэ албан хаагчийн тэтгэмж урамшуулал, төрийн үйлчилгээний ажилтны хөлс, шилэн данс, төсвийн тухай хууль, анхан шатны баримт хөтлөлтийн талаар тус тус мэдээлэл өгч ажиллалаа.

### **ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн Засаг даргаас 05 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 379 шийдвэр батлагдан гарсан бөгөөд тус шийдвэрүүдийг аймгийн [www.uvurkhangai.mn](http://www.uvurkhangai.mn) цахим сайтад байршуулан иргэдэд мэдээллийг шуурхай авах боломжийг ханган ажиллаж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс хамтран “Хуулийн байгууллагуудын нээлттэй өдөрлөг”-ийг бүх сумдад зохион байгуулахаар төлөвлөсний дагуу Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин, Бат-Өлзий, Арвайхээр сумдад ажиллаж, иргэдэд хууль, эрхзүйн мэдлэг олгож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжуудыг сурталчлахаас гадна дээрх сумдад нийт 1000 гаруй иргэнд хуулийн байгууллагууд бүх төрлийн хуулийн үйлчилгээг газар дээр нь хүргэж ажилласнаас архивын лавлагаа, хуулбар, ажилласан жил, эцэг тогтоолгох, хүүхэд үрчлэлт, галт зэвсэг эзэмших, ашиглах, жолооны үнэмлэх нөхөн авах, эрх сэргээх, иргэдийн зөрчигдсэн эрхийг сэргээх, өмгөөлөл авахтай холбоотой 500 гаруй иргэний хүсэлтүүд, бусад өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж ажилласан байна.

Монголын Хуульчдын холбоо, Хууль зүйн туслалцааны төвөөс орон нутагт ажиллаж иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, зөвлөгөөг өгөх чиглэлээр хамтран ажиллалаа. Энэ үеэр Арвайхээр сумын нийт 40 гаруй иргэнд хууль зүйн туслалцааг өгч ажилласан байна.

Аймгийн архивын тасагт байгууллага, иргэдээс 667 өргөдөл хүлээн авч 288 лавлагаа, 1052 хуулбар, 113 тодорхойлолт олгоод байна.

“Архивын тоо бүртгэл, эрэл хайлтын программ”-д 432 хадгаламжийн нэгжийн 35048 хуудас, 21543 заалт, 184830 хүний нэр, 26041 байгууллагын нэр 30779 газар зүйн нэр бүхий захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Мөн 309 хадгаламжийн нэгжийн 34201 хуудас баримтыг PDF файл үүсгэн цахим холболтыг хийн, 416 хадгаламжийн нэгжийн 29599 хуудас баримтыг скайнердаж, 428 хадгаламжийн нэгжийн 29838 хуудас баримтыг Photoshop программд оруулсан байна.

### **ЦАГДААГИЙН ГАЗАР**

Эхний 5 сард 1906 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь 721 буюу +60.8 хувиар өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 416, зөрчлийн шинжтэй 1490 гомдол мэдээлэл бүртгэгдэн шалгаж байна.

Нийт бүртгэгдсэн Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 346 буюу 84,5 хувийг 5 хоногт, 58 буюу 13,9 хувийг 6-аас дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 1104 буюу 74.1 хувийг 3 хоногт, 196 буюу 13.1 хувийг 4-өөс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 91 нь буюу 6.1 хувийг шийдвэрлээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

Аймгийн хэмжээнд 05 сард 181 холбогдогчтой, 886.4 сая төгрөгийн хохиролтой, 275 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 48 хэргээр буюу +21.1 хувиар өссөн, хэргийн илрүүлэлт 30.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -7.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэргийн төрлөөр нь авч үзвэл хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг 10 бүртгэгдэж, 5 буюу +2.0 дахин, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 23 бүртгэгдэж 18-аар буюу +4.6 дахин, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 20 бүртгэгдэж 8-аар буюу +66.6 хувь дахин, залилах гэмт хэрэг 14 бүртгэгдэж 10-оор +3.5 дахин, тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 8 бүртгэгдэж 12-аар буюу +60.0 дахин буурсан, мал хулгайлах гэмт хэрэг 29 бүртгэгдэж 22 буюу +4.1 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 4 бүртгэгдэж, 2-оор буюу +3.0 дахин, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 16 бүртгэгдэж 3-аар буюу +4.0 дахин тус тус өссөн байна.

Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 73 бүртгэгдэж 14-ээр буюу 16.1 хувиар буурсан, авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7 бүртгэгдэж 11-аар буюу -55.0 хувиар буурч, албан тушаалын гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Өмчлөх эрхийн эсрэг 138 гэмт хэрэг бүртгэгдснээс иргэдийн өмчийг хулгайлах төрлийн 63, малын хулгайлах гэмт хэрэг 29, тээврийн хэрэгсэл хулгайлах 8, дээрэмдэх 4, залилах 14 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 46 буюу +50.0 хувиар өссөн байна.

Нийт бүртгэгдсэн 13636 зөрчлөөс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 890 зөрчил байгаа нь өмнөх оны мөн үеэс 171-аар буюу 23.7 хувиар өссөн байна.

### **ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөрмонголын өөртөө засах орны Хөх хотын Олон улсын монгол эмнэлэгтэй хамтран ажиллах, уламжлалтын эмч, мэргэжилтнүүдийн зүү заслын эмчилгээний нэр төрөл, чадварыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн эмнэлгийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор хамтын ажиллагааны санамж бичиг боловсруулан баталгаажуулав. Мөн энэ үеэр БНХАУ-ын Ян хотноо Гуан Дун мужид “Нэг бүс нэг зам” төслийн хүрээнд олон улсын

эмнэлэгүүдийн хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх форум уулзалтад ЭМГазар, БОЭТ-ийн төлөөлөгч нар оролцлоо.

Олон улсын сувилагчдын өдрийг угтан улсын нэгдсэн арга хэмжээг “Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, БОЭТ-ийн сувилахуйн албаны баг хамт олон хамт олноо манлайлан, улсын арга хэмжээнд оролцлоо. Мөн энэ үеэр сувилахуйн удирдах ажилтны зөвлөгөөнд төлөөлөгч оролцож Монголын сувилагчдын нийгэмлэгийн үйл ажиллагаатай танилцлаа.

УИХ-ын гишүүн МАН-ын дарга Д. Тогтохсүрэнгийн ивээл дор “Эелдэг харилцаа, Эерэг хандлага” сэдэвт залуу эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон гаргаж УИХ гишүүн болон орон нутгийн удирдлагуудад хүсэлт болгон өглөө.

“Нийгмийн эрүүл мэндэд эмч эмнэлгийн мэргэжилтний үүрэг оролцоо” сэдэвт эссэ бичлэгийн Улаанбурхан, Улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг ЭМС-ын 2019 оны 207-р тушаал, аймгийн Засаг даргын захирамж, Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/22 дугаар тушаалыг батлуулан удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж дархлаажуулатын хувь 84 хувьтай байна.

Байгууллагын ажилтнуудад “Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн ойлголт, эргономикийн асуудал”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт 2 сургалт зохион байгуулсан. 18 ажилтанд оффисын эргономик, эргономикийн хүчин зүйлстэй холбоотой эрүүл мэндийн нөлөөлөл, тав түхгүй байдлыг үнэлэх 2 төрлийн хяналтын хуудсуудаар үнэлгээ хийхэд 82.6 хувь нь ажлын байр нь стандартын шаардлага хангасан, эргономикийн хүчин зүйлсээс хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл нь бага гэсэн дүгнэлтийг өгсөн.

Эрүүл мэндийн газар, эх баригчдын нийгэмлэгтэй хамтран “Харилцан суралцахуй” сэдэвт сургалт харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулж олон улсын эх баригчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ.

Залуу гэр бүлийн өдөрлөгийг ГБХЗХГазар, Хүний хөгжлийн газар, Нийгмийн халамж үйлчилгээний төвтэй хамтран зохион байгуулж урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 40 гаруй залуу гэр бүлийг хамруулан ажиллалаа.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч, вакцинатор, сургуулийн эмч, нийгмийн ажилтан нарын 100 хүнийг хамруулан Улаанбурхан, Улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтын сургалтыг зохион байгуулав.

## **БОЛОВСРОЛЫН САЛБАР**

Энэтхэг улсын засгийн газрын тэтгэлгээр суралцах нийт 17 хүсэлт гаргагчаас анхан шатны англи хэлний шалгалтыг авах ажлыг зохион байгууллаа. Шалгалтын үр дүнд нийт 12 шалгуулагч тус шалгалтад тэнцэн дараагийн шатны өргөдөл анкетаа бөглөх, хүсэлт гаргах саналыг хүргүүлэн ажиллав.

Анги нийтийн олимпиадын 2-ын давааны эхний шатанд шалгарсан ангиудаас шалгалт авах ажлыг зохион байгуулав.

АНУ-ын ЭСЯ-ны ОНХА-ны дарга болон хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүд Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1,2 дугаар сургуулийн 7-8 дугаар ангийн сурагчдад үзүүлэх хичээл заах, Арвайхээр ерөнхий боловсролын 4, Мэргэд сургуулийн 11-р ангийн сурагчдад АНУ-д сурах боломж, хамрагдах хөтөлбөрийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажиллалаа.

Англи хэлний хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгөх аймгийн нийт 24 сургуулийн 12 дугаар ангийн 309 сурагчдаас сорил авч дүн мэдээг сурагчдын оноо, гүйцэтгэлээр дундаж оноог гарган явууллаа.

“Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хамтдаа” мэдээллийн яармаг зохион байгуулж сургуулийн үүдэнд байрлах ТВ-ээр дамжуулан хүүхэд хамгааллын талаарх дүрс бичлэг, видео шторк үзүүлэн хэлэлцүүлэг хийж багш нар эцэг эхчүүд нийт 1075 хүнд мэдээлэл өгч гарын авлага зөвлөмж тарааж өгөв.

Түүхийн хичээлийн улсын олимпиад Дорнод аймгийн Халхгол суманд амжилттай зохион байгуулагдаж 1 багш хүрэл медаль, 1 сурагч тусгай байрт тус тус шалгарав.

Улсын мэдээлэл зүйн 13 дугаар олимпиад Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдаж, бүтээлийн төрөлд 1 сурагч тусгай байрт шалгарсан байна.

### **БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР**

Таеквондогийн аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг Спортын ордны Б зааланд өсвөр үе, насанд хүрэгчид гэсэн ангиллаар зохион байгууллаа. Тэмцээнд Өвөрхангай, Орхон, Булган, Баянхонгор аймгийн болон Өвөрхангай аймгийн Хархорин, Хайрхандулаан сумдын нийт 9 байгууллагын 220 тамирчин оролцлоо. Өсвөр насны ангилалд: Өвөрхангай аймгийн “Шонхор” клуб, Орхон аймгийн “Титан таеквондо” сургалтын төв, Хархорин сум, насанд хүрэгчдийн ангилалд: 1-р байранд Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар, Зэвсэгт хүчний 256-р анги, Хархорин сумын баг тус тус эхний байрыг эзэллээ.

Монголын мастеруудын Биеийн тамир, спортын хорооны Өвөрхангай аймаг дахь салбар хорооны нэрэмжит софт волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Арвайхээр хотноо аймгийн Биеийн тамир, спортын газар, Монголын мастеруудын Биеийн тамир спортын хорооны Өвөрхангай аймаг дахь салбар хороо, аймгийн Софт волейболын холбоо хамтран зохион байгууллаа. Тэмцээнийг 35-49 нас, 50-59 нас, 60-аас дээш гэсэн 3 насны ангиллаар зохион байгуулж 21 байгууллагын 130 гаруй тамирчин хамрагдлаа.

Гучин Ус сумын харъяат аймгийн хүчит арслан Д.Аюушжавын нэрэмжит 2019 оны насанд хүрэгчдийн үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах барилдаан Гучин-Ус суманд зохион байгуулагдлаа. Барилдаанд 14 сумын 28 бөх 2 хэсэгт барилдан хэсэг тус бүрээс 5 бөх, шигшээ барилдаанд 10 бөх барилдан хувийн дүнгээр эхний 8 байрт шалгарсан бөхчүүдийг шагнаж урамшууллаа.

Жүдо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Хэнтий аймагт зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Б.Очир дасгалжуулагчтай Хангай жүдо бөхийн клубын тамирчид оролцож 55 кг Х.Батцэнгэл, 90кг Ж Базаргарьд нар түрүүлж Ази болон Дэлхий аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.

Олон улсын олимпийн өдрийг угтсан "Буухиа гүйлт - 2019" "Сүхбаатар"-ын талбайд зохион байгуулагдлаа. Буухиа гүйлтийн тэмцээнд аймаг, дүүргийн төлөөлөл өсвөрийн шилдэг тамирчдаас бүрдсэн нийт 40 багийн 300 тамирчид оролцсон оролцлоо. Тэмцээнд 8 тамирчин оролцож мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ.

Монголын хүүхдийн спортын VI их наадмын хангай бүсийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн 05 дугаар сарын 03-04 нд Орхон аймагт зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд А.Сумьяа багштай Арвайхээр сумын хөвгүүдийн баг, Сүхболд дасгалжуулагчтай Хархорин сумын охидын багууд оролцож тус тус 2 дугаар байр эзэлж шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.

### **ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Эхний 5 сарын байдлаар байнгын 346, түр 42, улирлын чанартай 14 нийт 402 шинэ ажлын байр бий болсон байна. Шинэ ажлын байрыг эдийн засгийн салбар

ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 15%, боловсруулах үйлдвэрлэлд 31%, бөөний худалдаа 9%, боловсролын салбарт 14%, бусад салбарт 31% тус тус байна. Шинэ ажлын байрыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 165 буюу 47 % нь төсвийн байгууллага, 181 буюу 53 % нь хувийн хэвшилд бий болсон байна.

Тухайн сард аймгийн хэмжээнд 313 ажил хайгч иргэний бүртгэлийг хөтөлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэн. Ажил хайгч иргэдийн бүртгэлд 1841 иргэн бүртгэлтэй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд 286 иргэнийг, бүлгийн зөвлөгөө мэдээлэлд 244 иргэнийг хамруулж, хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системд бүртгэлээ.

Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагаас 305 ажлын байрны захиалга хүлээн авч 275 иргэнийг ажлын байранд зуучиллаа.

Ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид хамрагдах 11 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар бүртгэн Нийгмийн даатгалын хэлтэст шилжүүллээ.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөрийн мэргэжлийн сургалтыг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран "Хоол үйлдвэрлэл, тогооч"-ийн мэргэжлээр Хархорин суманд 20 иргэнд 180 цагийн сургалт зохион байгуулж 2.520.0 мянган төгрөгийн санхүүжилт зарцуулсан.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт боловсрол, хөдөө аж ахуй, төрийн захиргааны чиглэлээр 14 төсөл хүлээн авч зөвлөх үйлчилгээг эхлүүлэн ажиллаж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн гарааны бизнесийг дэмжих "Старт апп" арга хэмжээнд 15-34 насны залуусын бизнес санааны сонгон шалгаруулалтыг зарлаж, 41 бүлгийн 94 иргэнийг бүртгэн төслийг хүлээн авч хянан үзэж байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 16 сумын 89 иргэнд 260,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож ажиллалаа.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 19 сумаас 33 төслийг хүлээн авч, Арвайхээр, Өлзийт сумдад тохижилт ногоон байгууламжийн ажилд хөдөлмөрийн насны ажилгүй 60 иргэнийг хамруулж, түр ажлын байраар хангаж ажиллалаа.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээний хүрээнд хүнсний ногоо тариалах хүсэлтэй 14 сумын 30 бүлийн 120 иргэнийг хамруулж төмс, төл сонгины үр өгч тариалалтын ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтарсан "Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж 19 сумын 95 иргэнийг хамрууллаа.

Улс, орон нутгийн төсвөөс халамжийн тэтгэвэрт 997.6 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 531.9 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 361.4 сая төгрөг, ахмад настаны нийгмийн халамжийн үйлчилгээнд 289.3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 103.4 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 160.2 сая төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 623.6 сая төгрөг, банкны шимтгэл, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллын зардалд 8.5 сая төгрөг, алдар цолтон ахмад настнуудын тэтгэмжид 38.0 сая төгрөг, алдарт эхийн тэтгэмжид 1350.4 тэрбум төгрөг, насны хишгийн зардалд 470.0 сая төгрөг, өрх толгойлсон эх эцгийн тэтгэмжид 89.6 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 10.8 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 1232.6 сая төгрөгийн санхүүжилтийг нийт 6257.0 тэрбум төгрөгийн



санхүүжилтийг авч нийгмийн халамжийн тэтгэвэрт 1472 иргэнд 965.2 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 2124 иргэнд 534.1 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 1718 иргэнд 352.2 сая төгрөг, ахмад настны нийгмийн халамжийн үйлчилгээнд 6537 иргэнд 255.7 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 475 иргэнд 80.0 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 1592 иргэнд 143.7 сая төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 5368 иргэнд 425.8 сая төгрөг, алдар цолтон ахмад настнуудын тэтгэмжид 37 иргэнд 24.3 сая төгрөг, алдарт эхийн тэтгэмжид 10084 иргэнд 1331.2 тэрбум төгрөг, насны хишгийн зардалд 5383 иргэнд 452.5 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 6609 иргэнд 1152.2 сая төгрөг, өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 266 иргэнд 84.0 мянган төгрөг, банкны шимтгэлд 3.0 сая төгрөг нийт давхардсан тоогоор 41665 иргэнд 5803.9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаагийн хуралдаан зохион байгууллаа. Хурлаар нийт 15 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, 4 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 10 хүүхдэд байнгын асаргаа шинээр тогтоосон. 1 хүүхдийн байнгын асаргааг эдгэрч сайжирсан шалтгаанаар цуцалсан болно. Хурлаар хэлэлцсэн хүүхдүүдээс 5 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооноос санаачлан зохион байгуулсан “Тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх” сургалтанд оролцогч ерөнхий боловсролын I болон IV дүгээр сургуулийн 35 багш, ажилчдад “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ын үйл ажиллагааны талаар болон нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

### **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй үйл ажиллагааг эрчимжүүлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхдийн төлөө зөвлөл, Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөл, Хамтарсан баг, Хүүхдийн элч, аж ахуйн нэгж байгууллагын дэргэдэх Гэр бүлийн зөвлөлийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хэлэлцэж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хүрээнд хэрэгжилтийг хангах хууль тогтоомжийг сурталчилан таниулах зорилгоор Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Баян-Өндөр, Хархорин, Зүүнбаян-Улаан, Хужирт, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Сант, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Богд сумдад ажлын хэсэг ажиллав.

Хөгжлийн бэрхшээлтэй дотуур байранд амьдардаг бүтэн өнчин нэг хүүхдийг нийгмийн халалмжийн үйлчилгээнд холбон зуучилж, тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэн ажилласан.

“Хүүхэд нэг бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн хүрээнд Японы хүүхдийг Ивээх сангаас зохион байгуулсан аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн Тусгай бүлгийн сурагчдын 35 эцэг, эхчүүдэд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдвээр сургалт зохион байгууллаа.

“Олон Улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан залуу гэр бүлийг дэмжих, төрийн бодлого үйл ажиллагааг сайжруулахад сум орон нутгийн залуучууд шууд болон төлөөллөөрөө дамжуулан тулгамдсан асуудлынхаа талаар шийдвэр гаргах түвшинд санал бодлоо илэрхийлэх, тэдний ашиг сонирхлыг нэгтгэж, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий “Залуу гэр бүлийн клуб” байгуулах, өөрсдийн авъяас, хөдөлмөр, зүтгэл, идэвх санаачилгаараа залуу үеийнхнийгээ

манлайлан амьдарч буй шилдэг гэр бүлүүдийг алдаршуулах өдөрлөгийг зохион байгууллаа.

ДЗОУБ-ын Өвөрхангай ОНХХ-ийн "Хамтдаа хөгжсөн 17 жил" хаалтын үйл ажиллагаанд тус газрын дарга мэргэжилтнүүд оролцож, хүүхэд хамгааллын өртөөг ажиллуулж, иргэдэд мэдээлэл өглөө.

"Тогтвортой гэр бүл-Улсын үндэс" аймгийн залуу гэр бүлийн 2-р чуулганыг зохион байгууллаа. Арга хэмжээнд 19 сумын төлөөлөл малчин, хувиараа бизнес эрхлэгч, төрийн албан хаагч 50 гэр бүлийн 100 гэр бүлийн гишүүд оролцуулсан. Тус өдөрлөгөөр аймгийн хэмжээнд цаашид залуу гэр бүлийн төлөөлөл болон ажиллах гэр бүлрүү чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор 9 гэр бүлийг тэргүүлэгчээр сонгон, аймгийн залуу гэр бүлийн клубыг шинэчлэн байгууллаа.

"Монгол Өрх" сэтгэл заслын хүрээлэнтэй хамтран "СЭТГЭЛЗҮЙН ДАРХЛААЖУУЛАЛТ" аяныг зохион байгууллаа. Тус аяны хүрээнд хүрээлэнгийн сэтгэлзүйчид ажиллаж "Хүүхдийн ордон"-д лекц, сургалт зохион байгуулж, ганцаарчилсан болон бүлгийн сэтгэлзүйн зөвлөгөөг өгч, оношилгоо хийж, 600 хүнд хүрч ажилласан.

НҮБ-ын Хүн амын сангийн албаны хүмүүсийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Өвөрхангай аймагт ажиллах үеэр тус газрын дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах асуудлаар хэлэлцэж, уг төвийг барих нарийвчилсан төлөвлөгөөг гарган, цаашид үзүүлэх дэмжлэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга зүйн зөвлөмжийн талаар санал солилцсон.

"Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"- ийг тохиолдуулан хүүхэд өсвөр үеийнхэнд танин мэдүүлэх, монгол үндэсний бичиг соёлоо өсвөр болон залуу үедээ өвлүүлэх, сурч эзэмших хүсэл эрмэлзлийг төрүүлэх зорилгоор "Босоо бичиг мину" монгол бичгийн аймгийн анхдугаар уралдааныг амжилттай зохион байгууллаа. Тус уралдааныг Арвайхээр сумын ЕБ-ын 4 сургуулийн 7-12-р анги, МСҮТөвийн сурагчдын дунд зарлаж шалгаруулалтыг хийсэн. Уг уралдаан нийт 179 сурагч оролцож, шилдэг бүтээлээрээ шалгарсан 34 сурагчдын шагналыг Хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 94 жилийн ойн баярын өдрөөр гардууллаа.

Хүүхэд, өсвөр үеийнхэнд Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, эзэмшүүлэх, өвлүүлэх, сурталчлах, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, харилцан суралцах, хамтран уран бүтээл туурвих Монгол үндэстний соёл урлаг, зан заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор "Монголын хүүхдүүд" урлагийн наадмын II шат буюу "Хангайн бүс"-ийн наадмыг Монголын Хүүхдийн ордонтой хамтран зохион байгууллаа. Уг наадамд Өвөрхангай, Баянхонгор, Хөвсгөл, Архангай гэсэн 4 аймгийн нийт 200 гаруй авьяаслаг хүүхэд багачууд оролцон, өөрсдийн авьяас, ур чадвараараа өрсөлдөж, II шатанд 54 хүүхэд шалгарч, III шатны наадамд оролцох эрхийн бичгийг гардууллаа.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 5-р сард орон нутагтай холбоотой хүүхдийн эрх зөрчигдсөн багшийн ёс зүйтэй холбоотой 9 дуудлага, кейс мэдээлэл ирж, харъяалах сумын хамтарсан багт холбон зуучилж, шилжүүлэн нөхцөл байдлыг судлуулан ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нэг хүүхэд, эмэгтэйг Хамгаалах байранд хүлээн авч, сэтгэлзүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллийг өгч, нийгмийн ажил үйлчилгээг үзүүлж ажилласан.

Насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн 1 хүүхэд болон гэмт хэргийн хохирогч болсон 5 хүүхдийн мэдүүлэг авах байцаалтанд хууль ёсны төлөөлөгчөөр тус

газрын мэргэжилтнүүд оролцож, хүүхдийн эрхийн аюулгүй байдалд хяналт тавин ажиллаж байна.

Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа эрчимжүүлэх, иргэд олон нийтэд сурталчилах, уялдаа холбоог хангах, төрөөс баримтлах бодлого төлөвлөлтийг танилцуулах, харилцан туршлага солилцох, бүтээлчээр манлайлах боломжийг бүрдүүлэх зорилгоор “ЭЕРЭГ ХАНДЛАГА-БҮТЭЭЛЧ САНАА” төрийн бус байгууллагуудын анхдугаар чуулганыг зохион байгууллаа. Тус чуулганд 130 гаруй ТББ-ын төлөөлөл оролцож санал бодлоо солилцсон.

### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**

“Үлийн цагаан огтонотой тэмцэх арга хэмжээг санхүүжүүлэх, хуваарь батлах” Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А/86, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/118 дугаар тушаал “Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай”, аймгийн Засаг даргын 2019 оны А/247 дугаар захирамжыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Есөнзүйл, Тарагт, Хархорин зэрэг сумдын 30.0 мянган га газар микробиологийн аргаар бактержуулсан 60 тонн будаа цацаж бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготно устгах ажлыг зохион байгуулаад байна.

“Аймгийн малчдын зөвлөгөөн-2019” арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран “Малын чанарыг сайжруулж, ашиг шимийн үнэлэмжийг нэмэгдүүлье” уриан дор амжилттай зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд төлөөлөгчөөр нийтдээ 400 малчид оролцлоо. Зөвлөгөөний үеэр Монгол улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймгийн Засаг дарга Г.Ганболд, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Цэдэнбалжир, Монголын бэлчээр ашиглалтын холбооны гүйцэтгэх захирал Н.Ганхуяг, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга Б.Цэнгэл, Үйлдвэр худалдаа үйлчилгээний албаны дарга Ц.Ариунаа, аймгийн Мал эмнэлэгийн газрын дарга А.Нямдаваа болон бусад албаны хүмүүс илтгэл тавьж төлөөлөгчдийн асуусан асуултанд хариулт өглөө. Тус зөвлөгөөнөөс 9 заалт бүхий уриалга баталлаа.

Баянгол омгийн 500 гаруй хонинд ангилалт хийж 2018 оны зохиомол хээлтүүлэгийн төлд жигнэлт хийж 200 гаруй хургыг ээмэглэж шинээр 45 хургыг өсвөр хээлтүүлэгчээр сонгож тавиад байна.

Монгол Улсын Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын хамтарсан “Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэг зохион байгуулах тухай удирдамж”-ийн дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/289 дүгээр захирамжаар орон нутагт улсын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулав.

Аймгийн хэмжээнд 2011-2018 онд нийт 15.2 тэрбум төгрөгийг 3207 төсөлд олгож нийт 3988 ажлын байр шинээр бий болж, 2321 ажлын байр хадгалагдаж, зээлийн эргэн төлөлт 84.9 хувийн гүйцэтгэлтэй хэвийн явагдаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/119 дүгээр тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас манай аймагт 1.0 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр хуваарилагдсан. Үүний дагуу төсөл сонгон шалгаруулах аймгийн дэд хорооны бүрэлдэхүүн аймгийн Засаг даргын 2019 оны А/342 дугаар захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдав. Хөнгөлөлттэй зээл хүсэж ирүүлэх төслүүдийг 5 дугаар сарын 27-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдрүүдэд Соёмбо телевиз, “Өвөрхангай” сонин, [uvurkhnangai.mn](http://uvurkhnangai.mn) сайт, Хүнс, хөдөө

аж ахуйн газрын пэйж хуудас, мэдээллийн самбараар олон нийтэд нээлттэй зарлаад байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах аймгийн дэд хорооны бүрэлдэхүүнийг чадавхжуулах бүсийн сургалтыг ХХААХҮЯамтай хамтран Арвайхээр суманд зохион байгуулж Архангай, Баянхонгор, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хорооны гишүүд оролцлоо.

Монгол Улсын Хүнсний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 болон 16.2 дахь заалтын дагуу “Баяжуулсан бэлдмэл, хүнсний нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ын төсөлд санал авах хэлэлцүүлгийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлээ.

Монгол улсад атар газар эзэмшиж, газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэй бие даасан салбар болгон хөгжүүлсэний түүхт 60 жилийн ойн арга хэмжээний нээлт, газар тариалангийн зөвлөгөөнийг Арвайхээр, Хархорин суманд тус тус зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд нийтдээ 260 гаруй ахмад болон дунд үеийн тариаланчид оролцлоо. Дээрх арга хэмжээнд Улсын их хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Монголын тариаланчдын үндэсний холбооны дэд дарга Ц.Ренчинсэнгээ, аймгийн Засаг дарга Г.Ганболд нар оролцож газар тариалангийн салбарт төрөөс баримталж байгаа бодлого шийдвэрийн талаар танилцууллаа. Зөвлөгөөний үеэр атрын 60 жилийн ойн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулан, хамтран ажиллах мэргэжлийн холбоод болон ТББ-д гардуулан өгч илтгэл, мэдээллүүд хүргэлээ. Мөн тариаланчид тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээ, анхаарах асуудлын талаар хэлэлцлэв. Мөн атар газар эзэмшиж, газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэй бие даасан салбар болгон хөгжүүлсэний түүхт 60 жилийн ойн хүрээнд аймгийн хэмжээнд туг аялуулахаар шийдвэрлэн аяны тугийг Арвайхээр суманд гардуулаад байна.

“Хүнсний ногоо” хөтөлбөрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 6 төрлийн нарийн ногооны үр хуваарилсныг сумдад хүргэж, “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 7 сумын 68 иргэнд 2892 чацарганы суулгацыг 6 жилийн хугацаатай хүүгүй зээлээр олголоо.

Аймгийн хэмжээгээр 05 дугаар сарын 27-ны байдлаар 4465,5 га-д тариалалт хийж 4300 га-д улаан буудай, 123 га-д төмс, 42,5 га-д хүнсний ногоо тариалж хаврын тариалалт 37,4 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд энэ онд 8 төрлийн халдварт өвчнөөс эмчилэн сэргийлэх, вакцинжуулалт хийгдэхээс Шөвөг яр-100%, Галзуу 55%, Дуут хавдар 45%, Цусан халдварт 80%, ДХХ 68 хувийг МЭҮНэгжийн малын эмч нарт тараагдаад байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг технологийн дагуу хийж нийт 1645,9 мянган толгой мал хамрагдахаас одоогийн байдлаар 651,9 мянган толгой мал буюу 39,6 хувь нь хамрагдаад байна.

Мал эмнэлгийн газрын даргаар батлуулсан “Хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу сумдын МЭТ, МЭҮН-ийн үйл ажиллагаатай танилцаж, мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт, нэгжүүд стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах, зөвлөгөө өгөх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, чанар, малчин өрхүүдэд ажиллаж, өрхийн малын эрүүл мэндийн дэвтрийн хангалт, хөтлөлтийг хянах, малчдаас санал асуулгын хуудсаар асуулга авч, малын вакцин, эм бэлдмэлийн хүрэлцээ хангамж, мал эмнэлгийн ажил үйлчилгээтэй холбоотой асуудлаар тэдний санал хүсэлтийг

сонсож, мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, малын эмийн зохистой хэрэглээ, түүний үлдэгдлийн талаар малчдад сурталчиллаа.

### **ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

“Хархорин-Ус суваг” ХХК, “Хужирт эрдэс баялаг” ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийг томилох, Уянга сумын Жаргалант багийн цэцэрлэгийн хуучин барилгын асуудлыг шийдвэрлэв.

Энэ сард төрийн байгууллагуудын засвар, тоног төхөөрөмж, эрүүл мэнд, боловсролын салбарын их засвар, тоног төхөөрөмж, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар, аймаг дахь Цагдаагийн газарт тээвэр шатахуун нийлүүлэх, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ISO-9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, Хархорин, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга сумын соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмж, “Баянтээг” ХК-д экскаватор нийлүүлэх, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хужирт сум Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, тоног төхөөрөмж, Өргөгч машин, Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан сумдын сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар, “Баянтээг” ХК-ийн нүүрсийг коксжуулж, Био холбогчтой бүрэн шаталттай шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэрийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр байгуулах, Богд сумын цаг уурын станцын барилга зэрэг улс, орон нутгийн төсөв, байгууллагын захиалга нийлээд 10 гаруй тендерийг зарлаад байна.

### **УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Энэ сард агаарын дундаж температур 3.5 – 9.3 градус дулаан, нийт нутгаар ихэнх хугацаанд шөнөдөө -9 градус хүйтнээс 2 градус дулаан өдөртөө 18-24 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулж үзвэл нийт сумдын нутгаар олон жилийн дунджаас 3.7-7.0 градусаар сэрүүн байсан бөгөөд 5 дугаар сарын 12 ны шөнө нийт нутгаар хүйтэрч Богд, Бат-Өлзий, Зүйл, Нарийнтээл, Өлзийт, Хайрхандулаан сумдын нутгаар -12-18 градус хүрч хүйтэрсэн байна.

**Орхон гол:** Бат-Өлзий сумын ус судлалын харуул усны түвшин олон жилийн дунджаас 4см-ээр их, дундаж гүн 20см, хамгийн их гүн 36см байгаа бол Хархорин сумын ус судлалын харуул орчим усны түвшин олон жилийн дунджаас 5см-ээр их, дундаж гүн 47см хамгийн их гүн 92см орчим байна.

Цаг агаарын нарийвчилсан мэдээ зохиож таарц нь 96.2хувь, хоногийн урьдчилсан мэдээ зохиож таарц нь 94.4 хувь, цаг агаарын аюул агаар мэдээний ирц болон чанар 100 хувь, цаг агаарын хоногийн урьдчилсан мэдээг аймгийн сум бүрээр нарийвчилан зохиож [www.tsag.agaar.mn](http://www.tsag.agaar.mn) цахим хуудсанд 30 удаа тавьж нийтийн хэрэгцээнд үйлчилсэн.

### **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Улсын төсвийн хөрөнгөөр Арвайхээр суманд баригдах Залуучуудын усан спорт цогцолборын барилга, 50 ортой хүүхдийн эмнэлэг, 320 хүүхдийн сургуулийн барилгуудын байршлыг хянан баталгаажуулж суурийн улаан шугамыг тавив.

Хужирт суманд баригдах 75 хүүхдийн цэцэрлэг, Өлзийт суманд баригдах сургуулийн спорт заал, Тарагт суманд баригдах спорт заал бүхий конторын барилгуудын байршлыг хянан баталгаажуулж, барилга угсралтыг эхлүүлэв.

Арвайхээр сумын шинэ суурьшлын 175 айлын хаус хорооллын барилгын болон инженерийн шугамыг дэвсгэрт оруулж улаан шугамыг тавихад бэлэн болгов.

## **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлээр нийт 416 хүнд үйлчилгээ үзүүлснээс төрөлт 232, үүнээс эрэгтэй 114, эмэгтэй 118, үрчлэлт 6, ургийн овог, эцгийн нэр, нэр өөрчлөлт 14, эцэг тогтоолт 12, гэрлэлт 64, үүнээс анхны 53, дахин 11, гэрлэлт цуцлалт 8, үүнээс захиргааны журмаар 2, шүүхийн журмаар 6, нас баралт 80, үүнээс эрэгтэй 55, эмэгтэй 25 тус тус байлаа. Дээрх 416 ширхэг ИУБ маягтыг мэдээллийн санд шивж оруулан, баталгаажуулж, галиглан ИУБ маягтын "А" талыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан тоотоор хүргүүлж, "Б" талыг аймгийн иргэний баримтын архивт байршууллаа.

Аймаг хотоос шилжин ирсэн 49 иргэн үүнээс насанд хүрэгч 25,16-аас доош насны 24 иргэн байлаа. Түүнчлэн аймаг дотор, баг хооронд шилжин суурьшсан 225 иргэний ИУБ-22 маягтыг мэдээллийн санд оруулж, баталгаажууллаа.

Тайлангийн хугацаанд нийт 541 иргэний цахим үнэмлэхийг олгосноос 16 нас хүрч авсан 125, иргэний паспортыг иргэний үнэмлэхээр сольсон 2, 25 насны сунгалт 135, 45 насны сунгалт 111 үүнээс хаяж үрэгдүүлсэн 162, овог нэр сольсон 5, төрсөн он тогтоолгосон 1 байлаа.

Үндэсний энгийн Е серийн гадаад паспорт шинээр захиалсан 181 иргэний материалыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүллээ.

## **СУМДЫН МЭДЭЭЛЭЛ**

Есөнзүйл суманд Зүүн хайрханы оройд Хайрханы Их Шүтээн "ЛХА И ГЭНЭН ЧИНБУУ" бурханыг залж, Зүүн хайрханы тэнгэрийг тайх тахилгын ёслолыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газар хамтран зуны эхэн сарын шинийн 8-ны билэгт сайн өдөр зохион байгуулж, "Зүүн хайрханаа"-аа 2 дахь удаагаа тайж тахин, зүүн бүсийн хурдан морины уралдаан, бэсрэг наадмыг зохион байгууллаа.

Хайрхандулаан сумын төвийн 6-р багийн ИНХ-ыг Сангийн яам, Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагийн төлөөлөгчдийн оролцоо, дэмжлэгтэйгээр хамтран зохион байгуулан азын сугалаа сугалуулж иргэдийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэн 160 гаруй иргэд оролцов. Мөн бусад зарим багууд хэрэглэн иргэдийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэн БИНХурлаа зохион байгуулав.

Баян-Өндөр суманд бүх нийтээр мод тарих үйл ажиллагаа зохион байгуулж улиас-200, чацаргана-600, монос-50, нохойн хошуу-200, шар хуйас-650 ширхэгийг тус тус тариаллаа.